

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2022/36/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойр хот
2022 он

Дарга тэргүүлэх аудитор:
Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер:
Утас: 7054-3179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор:
Утас: 7054-3179 Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	16
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.6.3 Нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГСА	Говьсүмбэр аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ЗД	Засаг дарга
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

**"БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР"-ЫН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ В.ГАНТУЯА ТАНАА**

2022.02.25 № 32

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Баянтал сумын ЗДТГ"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Баянтал сумын ЗДТГ"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020096

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	167,469,929.15	159,431,466.45
33	АВЛАГА	4,883,126.05	3,358,126.05
33500	Бусад авлага	4,883,126.05	3,358,126.05
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,883,126.05	3,358,126.05
34	УРЬДЧИЛГАА	368,670.40	218,670.40
34710	Урьдчилгаа тооцоо	368,670.40	218,670.40
35	БАРАА МАТЕРИАЛ	148,498,702.70	142,073,170.00
35100	Түүхий эд материал	23,287,905.00	22,863,780.00
35110	Тусгай зориулалттай материал	23,287,905.00	22,863,780.00
35400	Хангамжийн материал	125,210,797.70	119,209,390.00
35410	Бичиг хэргийн материал	1,124,037.00	962,037.00
35420	Аж ахуйн материал	21,439,233.70	14,969,826.00
35450	Барилгын засварын материал	1,848,000.00	478,000.00
35470	Бусад хангамжийн материал	100,799,527.00	102,799,527.00
36	НӨӨЦИЙН БАРАА	13,719,430.00	13,781,500.00
36300	Тэжээлийн нөөц	13,719,430.00	13,781,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,438,035,959.78	1,351,641,846.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,438,035,959.78	1,351,641,846.11
39200	Биет хөрөнгө	1,358,762,959.78	1,272,518,846.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,237,597,661.72	1,237,597,661.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	-243,396,602.87	-283,561,994.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл	206,976,430.00	154,226,430.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-162,319,066.58	-114,186,496.64
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	66,027,613.80	76,054,060.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-52,097,744.24	-49,030,438.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,877,428.62	77,324,928.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-59,040,531.01	-57,548,314.66
39214	Бусад үндсэн хөрөнгө	392,347,017.00	383,761,217.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-122,209,246.66	-162,118,206.81
39216	Дуусаагүй барилга, байгууламж	10,000,000.00	10,000,000.00
39300	Биет бус хөрөнгө	79,273,000.00	79,123,000.00
39301	Программ хангамж	2,980,000.00	2,980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,305,000.00	-2,455,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	78,598,000.00	78,598,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,605,505,888.93	1,511,073,312.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	1,312,126.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	1,312,126.00
41300	Өглөг	0.00	1,312,126.00
41360	Бусад өглөг	0.00	1,312,126.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	1,312,126.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,605,505,888.93	1,509,761,186.56
51	Засгийн газрын хувь оролцоо	1,605,505,888.93	1,509,761,186.56
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	753,426,290.17	753,426,290.17
51200	Хуримтлагдсан үр дүн	106,707,708.98	10,963,006.61
51210	Өмнөх үеийн үр дүн	-54,579,549.42	115,039,375.64
51220	Тайлант үеийн үр дүн	161,287,258.40	-104,076,369.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	745,371,889.78	745,371,889.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,605,505,888.93	1,511,073,312.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	637,368,251.00	429,690,330.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	258,277,151.00	37,789,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	258,277,151.00	37,789,100.00
120003	Торгуулийн орлого	233,654.00	631,324.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	223,545,000.00	24,741,120.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	34,498,497.00	12,416,656.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	379,091,100.00	391,901,230.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,870,000.00	34,613,630.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,765,000.00	9,346,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000.00	25,267,630.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	358,221,100.00	357,287,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	358,221,100.00	357,287,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	476,080,992.60	525,565,462.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	476,080,992.60	525,565,462.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	471,789,691.20	521,252,783.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,631,421.00	203,355,384.00
210101	Үндсэн цалин	209,631,421.00	142,810,836.00
210102	Нэмэгдэл	0	53,781,448.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	6,763,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,907,848.00	27,488,180.58
210201	Тэтгэврийн даатгал	26,907,848.00	19,548,664.00
210202	Тэтгэмжийн даатгал	0	2,138,771.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	1,650,535.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0	387,216.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0	3,762,994.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,498,065.60	62,224,625.00
210301	Гэрэл, цахилгаан	5,769,685.00	5,791,145.00
210302	Түлш, халаалт	46,943,531.60	52,471,632.00
210303	Цэвэр, бохир ус	3,784,849.00	3,961,848.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,307,496.00	60,780,954.70
210401	Бичиг хэрэг	5,014,612.00	5,723,034.00
210402	Тээвэр, шатахуун	20,986,772.00	19,559,936.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,725,332.00	2,426,846.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	180,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	11,883,080.00	23,415,067.00
210408	Бараа материал акталсны зардал	0	9,476,071.70
210409	Бараа материал шилжүүлсний зардал	7,557,700.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,148,900.00	12,489,600.00

Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	242,000.00	0
210604	Урсгал засвар	906,900.00	12,489,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,288,000.00	4,946,000.00
210702	Дотоод албан томилолт	1,288,000.00	4,946,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,055,015.00	3,708,668.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,651,000.00	2,869,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	1,399,575.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	182,600.00	155,628.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	462,840.00	199,940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,952,945.60	146,259,371.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,017,000.00	29,413,008.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,935,945.60	116,846,363.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,291,301.40	4,312,678.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,640,000.00	1,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,640,000.00	1,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,651,301.40	2,512,678.42
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,256,115.00	2,512,678.42
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	395,186.40	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	161,287,258.40	-95,875,132.16
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	8,201,236.87
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	8,201,236.87
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	161,287,258.40	-104,076,369.03

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	753,426,290.17	745,371,889.78	-51,431,449.42	1,447,366,730.53
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-3,148,100.00	-3,148,100.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	753,426,290.17	745,371,889.78	-54,579,549.42	1,444,218,630.53
4	Тайлант үеийн үр дүн	0	0	161,287,258.40	161,287,258.40
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	753,426,290.17	745,371,889.78	106,707,708.98	1,605,505,888.93
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	753,426,290.17	745,371,889.78	106,707,708.98	1,605,505,888.93
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	8,331,666.66	8,331,666.66
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	753,426,290.17	745,371,889.78	115,039,375.64	1,613,837,555.59
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-104,076,369.03	-104,076,369.03
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	753,426,290.17	745,371,889.78	10,963,006.61	1,509,761,186.56

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	389,036,300.00	393,607,796.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	389,036,300.00	393,607,796.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,815,200.00	36,320,196.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,765,000.00	9,346,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,050,200.00	26,974,196.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	358,221,100.00	357,287,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	358,221,100.00	357,287,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	384,876,460.00	388,027,096.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	384,876,460.00	388,027,096.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,341,408.60	383,116,417.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,126,614.00	203,000,000.00
210101	Үндсэн цалин	195,754,819.00	145,280,887.00
210102	Нэмэгдэл	11,437,605.00	51,604,553.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	934,190.00	6,114,560.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,652,100.00	27,238,804.58
210201	Тэтгэврийн даатгал	26,143,194.35	22,575,074.47
210202	Тэтгэмжийн даатгал	141,294.44	1,556,811.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	102,955.54	841,999.78
210204	Ажилгүйдлийн даатгал	24,059.84	201,882.06
210205	Эрүүл мэндийн даатгал	240,595.83	2,063,036.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,605,513.60	62,224,625.00
210301	Гэрэл, цахилгаан	5,877,133.00	5,791,145.00
210302	Түлш, халаалт	45,765,915.60	52,471,632.00
210303	Цэвэр, бохир ус	4,962,465.00	3,961,848.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,806,984.00	17,866,000.00
210401	Бичиг хэрэг	3,900,000.00	3,584,754.00
210402	Тээвэр, шатахуун	14,605,000.00	11,011,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,319,374.00	2,478,746.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	110,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	572,610.00	611,000.00
2105	Нормативт зардал	315,000.00	260,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	315,000.00	260,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,302,812.00	15,854,830.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,326,960.00	160,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	859,800.00
210604	Урсгал засвар	4,975,852.00	14,835,030.00
2107	Томилолт, зочны зардал	1,288,000.00	4,946,000.00
210702	Дотоод албан томилолт	1,288,000.00	4,946,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,080,615.00	22,926,988.00

Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,676,600.00	22,087,420.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	1,399,575.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	182,600.00	155,628.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	462,840.00	199,940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,163,770.00	28,799,170.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,163,770.00	28,799,170.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,535,051.40	4,910,678.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,883,750.00	2,398,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,883,750.00	2,398,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,651,301.40	2,512,678.42
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,256,115.00	2,512,678.42
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	395,186.40	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,159,840.00	5,580,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,159,840.00	5,580,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,159,840.00	5,580,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,159,840.00	5,580,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,159,840.00	5,580,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,159,840.00	-5,580,700.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	357,287,600.00	354,774,921.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	357,287,600.00	354,774,921.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	354,887,600.00	352,376,921.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,000,000.00	203,000,000.00
210101	Үндсэн цалин	139,931,300.00	145,280,887.00
210102	Нэмэгдэл	55,916,000.00	51,604,553.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,152,700.00	6,114,560.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,405,000.00	27,238,804.58
210201	Тэтгэврийн даатгал	19,285,000.00	22,575,074.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,030,000.00	1,556,811.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,624,000.00	841,999.78
210204	Ажилгүйдлийн даатгал	406,000.00	201,882.06
210205	Эрүүл мэндийн даатгал	4,060,000.00	2,063,036.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,902,800.00	62,224,625.00
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	5,791,145.00
210302	Түлш, халаалт	50,902,800.00	52,471,632.00
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	3,961,848.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,091,000.00	13,091,000.00
210401	Бичиг хэрэг	3,061,000.00	3,317,254.00
210402	Тээвэр, шатахуун	6,504,000.00	6,504,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,800,000.00	2,478,746.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	310,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	416,000.00	611,000.00
2105	Нормативт зардал	260,000.00	260,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	260,000.00	260,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,730,000.00	15,712,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,310,000.00	3,309,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	860,000.00	859,800.00
210604	Урсгал засвар	11,560,000.00	11,543,400.00
2107	Томилолт, зочны зардал	4,950,000.00	4,946,000.00
210702	Дотоод албан томилолт	4,950,000.00	4,946,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,191,000.00	4,860,422.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,170,000.00	4,150,794.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,072,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,000.00	155,628.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	212,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	70,000.00	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,357,800.00	21,043,170.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,357,800.00	21,043,170.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,400,000.00	2,398,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,400,000.00	2,398,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400,000.00	2,398,000.00

Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	357,287,600.00	354,774,921.58
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	357,287,600.00	354,774,921.58
320001	Орон нутгийн төсвөөс	357,287,600.00	354,774,921.58
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17	17
620001	Удирдах ажилтан	5	5
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	17	17
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7	7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	4	4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	36,320.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,320.20
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,320.20
2104	Хангамж, бараа материалын зардал	4,775.00
210401	Бичиг хэрэг	267.50
210402	Тээвэр, шатахуун	4,507.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,291.63
210604	Урсгал засвар	3,291.63
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,066.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,936.63
210807	Газрын төлбөр	129.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,187.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,187.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	36,320.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,320.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,320.20
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	9,346.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,974.20
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 37 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянтал сумын Засаг даргын Тамгын газар нь - Төрийн үйлчилгээг хурдан шуурхай ард иргэдэд нээлттэй, төрийн бодлого шийдвэрийг дагаж мөрдөхөд оршино гэсэн зорилт дэвшүүлсэн бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 84.6 хувьтай дүгнэгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 476,081.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,141.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,356.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 94,432.6 мянган төгрөгөөр буюу 6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	0.00
Авлага	4,883.13	3,358.13	-1,525.00
Урьдчилгаа	368.67	218.67	-150.00
Бараа материал	162,218.13	155,854.67	-6,363.46
Үндсэн хөрөнгө	1,438,035.96	1,351,641.85	-86,394.11
Нийт хөрөнгө	1,605,505.89	1,511,073.31	-94,432.58
Өр төлбөр	-	1,312.13	1,312.13
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,605,505.89	1,509,761.19	-95,744.70
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,605,505.89	1,511,073.31	-94,432.58

Авлага дансны үлдэгдэл 1,525.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өвсний авлагыг барагдуулсантай холбоотой байна. Авлага дансны эцсийн үлдэгдэлд 3,358.1 мянган төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага үлдэгдэлтэй тайлагнагджээ.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 368.7 мянган төгрөг болж өмнөх оноос 150.0 мянган төгрөгөөр буурч 218.7 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 155,854.7 мянган төгрөг болж 6,363.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оноос үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал буурсан, бараа материалыг акталж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,438,036.0 мянган төгрөг байсан ба 86,394.1 мянган төгрөгөөр буурч, 1,351,641.9 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын төсвөөс 5,580.7 мянга, сумын Засаг даргын 2021 оны А/125 дугаар тушаалаар 16,639.9 мянга, улсын төсвийн хөрөнгөөр буюу Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газраас 8,101.2 мянга, нийт 30,321.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэжээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 37 дугаар тогтоолоор 49,900.0 мянга, 2021 оны 42 дугаар тогтоолоор 39,193.7 мянга, нийт 89,183.7 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,312.1 мянган төгрөг болж нэмэгдсэн нь аймгийн Засаг даргын Тамгын газарт өвсний үнийг дутуу шилжүүлснээс үүссэн бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,509,791.2 мянган төгрөг болж 95,744.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн -104,076.4 мянга, нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулга 8,331.7 мянган төгрөгийн бичилт хийсэн нь нөлөөлжээ.

Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 207,677.9 мянган төгрөгөөр буюу 32.58 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 220,885.7 мянган төгрөгөөр буурч, нэмэлт санхүүжилтийн орлого 13,743.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 49,484.5 мянган төгрөгөөр буюу 10.39 хувиар буурсан байна. Үүнд: цалин хөлсний зардал 6,276.0 мянган төгрөгөөр буурч, байр ашиглалттай холбоотой 5,726.6 мянга, хангамж бараа материалын зардал 12,473.5 мянга, эд хогшил урсгал засварын зардал 11,340.7 мянга, томилолтын зардал 3,658.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 23,306.4 мянга нийт 56,505.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвийн санхүүжилт 475,793.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 475,793.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 131,505.7 мянган төгрөгөөр бууруулж, 344,287.6 мянган төгрөгөөр баталсан бөгөөд тайлант хугацаанд нийт 3 удаа төсөвт өөрчлөлт оруулж, жилийн эцсийн байдлаар 357,287.6 мянган төгрөгөөр санхүүжилтийг баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 357,287.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 357,287.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 357,287.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 354,774.9 мянган төгрөг зарцуулж, 2,512.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Хөтөлбөрийн код нэр	Арга хэмжээний код, нэр	Төлөв	Гүйц	Зөрүү
70106- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	302,767.8	300,808.5	1,959.3
	80106-Баг, хорооны ҮАЗардал	29,582.0	29,363.5	218.5
	80205-Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,300.0	1,281.7	18.3
	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж,	2,400.0	2,398.0	2.0

	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	10,000.0	10,000.0	-
	81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	1,867.8	1,867.8	-
	82212-Хур хог хаягдал, орчны бохирдол	6,000.0	5,706.0	294.0
	82310-Гамшигаас сэргийлэх сургалт, сурталчилгаа	3,370.0	3,349.4	20.6
	Нийт дүн	357,287.6	354,774.9	2,512.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц сангаас 3,906.0 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 3,810. мянга, тендерийн баримт бичгийн орлого 210.0 мянга, машин засварын зардлын буцаалт 3,291.6 мянга, аймгийн ИТХ-ын ГХУС хамтарсан багийн зардал 300.0 мянга, Дундговь аймгийн Онцгой байдлын газраас сэг зэм устгах арга хэмжээний зардал 1,000.0 мянга, өвсний борлуулалтын орлого 23,121.0 мянга, Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардал 500.0 мянга, цалингийн урьдчилгаа 181.7 мянга, нийт 36,320.3 мянган төгрөгийн орлогыг бүртгэж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцолсон.

3.8 Аудитын гол асуудал

Илрээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянтал сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд нийт 135,550.9 мянган төгрөгийн 149 мэдээллийг байршуулахаас 135,550.9 мянган төгрөгийн 147 мэдээллийг бүрэн байршуулж, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт холбогдох заалттай нийцсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Баянтал сумын Засаг даргын Тамгын газар нь өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 05 сарын 31-ны 203 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17,076.8 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 12,748.4 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 180.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3,966.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 181.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэж ирүүлээгүй нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 3 дугаар зүйлийн 3.1, санхүүгийн тайлангийн толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул завсрын аудитаар залруулсан.
2. Хагас жилийн санхүүгийн тайланд 1,354.4 мянган төгрөгийн өр төлбөрийг нэмэгдүүлж үүсгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дах заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул завсрын аудитаар залруулсан.
3. Мөнгөн гүйлгээний тайланд 2,431.0 мянган төгрөгийн худалдан авсан үндсэн хөрөнгийг үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар" 6 дугаар зүйлийн 6.4, 6.9, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, ангилал батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул аудитын явцад залруулсан.
4. Санхүүгийн үр дүнгийн тайланд элэгдлийн зардлыг 8,331.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.35 дах заалт санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад залруулсан.

5. Сахилгын арга хэмжээний суутгал 631.3 мянган төгрөгийн зардал бууруулах бичилт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад залруулсан.

4.2. Төлбөрийн акт

- 4.2.1. Хууль тогтоомжид тусгайлан заагаагүй 1,800.0 мянган төгрөгийн тэтгэмжийг байгууллагын дотоод журмын дагуу олгосон боловч 180.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2.2 дахь заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

4.3. Албан шаардлага

- 4.3.1. НД-ын тайланд Ц.Болдбаатарын 376.5 мянган төгрөгийн цалин хөлс 81.3 мянган төгрөгийн НДШ, ХХОАТ-ын тайланд Д.Сувд-эрдэнийн 653.7 мянган төгрөгийн цалин хөлс, 39.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын өр төлбөрийг тус тус тайлагнаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дүгээр зүйлийн 17.1.1, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалт санхүүгийн тайлангийн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т заасны дагуу албан шаардлага өгөв.

- 4.3.2 Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж цалингийн зардлаас 2,815.6 мянга урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2014 оны 5-р тушаалын 6 дугаар хавсралт, 2021 оны 190 дүгээр тушаал, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалингийн урьдчилгааны 181.6 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлж зарцуулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5.1 дахь заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч зарцуулахгүй байх, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалын дагуу нэмэлт санхүүжилтийн данснаас зарлага гаргах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянтал сумын Засаг даргын Тамгын газар	9	17,076.8	5	12,748.4	1	180.0	2	3,966.9	1	181.5